



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/11

Мөрөн сум

┌ Зохион байгуулалтын зарим арга
хэмжээний тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны 385 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хуралдааны шийдвэр, аймгийн Шуурхай штабын 2022 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын Омикрон хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын Омикрон хувилбарын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан Цагаан сарын баярыг нийтээр тэмдэглэхгүй зөвхөн гэр бүлийн хүрээнд цомхон тэмдэглэн өнгөрүүлэхийг иргэд олон нийтэд уриалсугай.

3. Бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, нутгийн зөвлөлийн болон хамт олны золголт хийхгүй байхыг байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Уралдаан тэмцээн, урлаг спорт, хурал зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулахдаа аймгийн Шуурхай штабаас зөвшөөрөл авч, заал дүүргэлтийг 50 хувиас хэтрүүлэхгүй байх, вакцинжуулалтын нэмэлт тундаа хамрагдсан эсэхийг нягтлан, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллахыг төрийн болон аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5. Төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэд ажлын байр, үйлчилгээний орчиндоо ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийх, нэг дор олон хүн цуглуулахгүй байх, үйлчилгээ авч буй иргэдийг вакцинжуулалтын нэмэлт тундаа хамрагдсан эсэхийг нягтлан, халдвар хамгааллын дэглэм, журмыг чанд мөрдөж ажиллахыг төрийн байгууллага, хуулийн этгээдийн удирдлагууд, иргэнд тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамжийн 5 дахь заалтад заасан үйл ажиллагаанд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, журмыг сахиулах, хяналт шалгалтыг чангатгах ажлыг зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, (Цагдаагийн дэд хурандаа

Т.Ганхуяг), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр), Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ё.Пүрэвсүрэн) нарт тус тус даалгасугай.

7. Мэргэжлийн байгууллагуудаас гаргасан коронавируст халдвар (Ковид-19)-ын Омикрон хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөх тухай зөвлөмж мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагууд, төрийн байгууллагуудын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнууд, төрийн албан хаагчидтай хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

8. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллахыг сумын Онцгой комиссын дарга, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр, дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

9. Коронавируст халдвар (Ковид-19)-ын Омикрон хувилбарын тархалтаас сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангуулах төлөвлөгөө, Улсын Онцгой комиссоос ирүүлсэн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), сумын Онцгой комиссын дарга нарт даалгасугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын орлогчийн 2022 оны 01 дүгээр сарын
14-ний өдрийн А/14... дугаар захирамжийн хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID19)-ЫН ОМИКРОН ХУВИЛБАРЫН ТАРХАЛТААС
СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, САНХҮҮ ХАНГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР				
1	Эрсдэлийн үнэлгээний дагуу шаардлагатай санхүү, нөөц, бэлэн байдалтай холбоотой судалгааг шинэчлэн гаргаж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хуэийн хамгаалах хэрэгсэл, урвалж, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн татан авалт, бэлэн байдлыг хангах	01 дүгээр сарын 20-ны дотор	Эрүүл мэндийн алба, төлөвлөлт, хяналт, нөөц, санхүү хөрөнгө оруулалтын баг	Эрүүл мэндийн байгууллагууд
2	Нөхцөл байдалтай холбогдуулан шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд улс, аймаг, сумын онцгой комисст танилцуулан, хомсдол үүсэхээс сэргийлэх ажлыг шуурхай авч ажиллах	Тухай бүр	Эрүүл мэндийн алба, төлөвлөлт, хяналт, нөөц, санхүү хөрөнгө оруулалтын баг	Аймаг, сумын Шуурхай штаб, Эрүүл мэндийн байгууллагууд
3	Одоо ажиллаж байгаа хүний нөөцийн судалгааг шинэчлэн гаргаж, нөөц бүрдүүлэлтийг хийх төлөвлөгөөг байгууллага бүрээр гаргах	01 дүгээр сарын 20-ны дотор	Эрүүл мэндийн алба, хүний нөөц, бэлэн байдал, сургалтын баг	• Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төв
4	Эрүүл мэндийн байгууллагуудад тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах тухай заавар зөвлөмжийг өгч, хяналт тавьж ажиллах	Тухай бүр	Эрүүл мэндийн алба, Хүний нөөц, бэлэн байдал, сургалтын баг	Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төв
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТАНДАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР				
5	Орон нутгийн халдварын үеийн эрсдэлийн үнэлгээг хийж, нөхцөл байдлыг тодорхойлон авах арга хэмжээний саналыг аймгийн Онцгой комисс, албадуудад танилцуулан, шийдвэр гарган хамтран ажиллах	Тухай бүр	Эрүүл мэндийн газар, Тандалтын баг	Эрүүл мэндийн байгууллагын тархвар зүйн баг, аймаг, сумын Шуурхай штаб
6	Эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, батлагдсан тохиолдлын тандалт судалгаа, ойрын хавьтлыг илрүүлэх, тусгаарлах, эмнэлзүйн тандалтыг хийх	Тухай бүр	Эрүүл мэндийн газар, Тандалтын баг	Тандалтын багийн гишүүд, холбогдох албад эрүүл мэндийн байгууллагууд

7	Гэрийн эмчилгээ, хяналтад байгаа иргэдийн тусгаарлалтын байдалд хяналт, тандалтыг үр дүнтэй хийж мэдээлэх	Тогтмол	Эрүүл мэндийн газрын тандалтын баг	Эрүүл мэндийн байгууллагын тархвар зүйн баг
8	Гадаадаас ирж буй иргэдийг бүртгэлжүүлж, гэрийн тусгаарлалтыг мөрдүүлэх	Тухай бүр	Эрүүл мэндийн газрын тандалтын баг	Эрүүл мэндийн байгууллагууд холбогдох албад, аймаг, сумын Шуурхай штаб
9	Улаанбаатар хот болон халдварын эрсдэл өндөртэй орон нутагт зорчсон иргэдийг 3-5 хоног гэрийн тусгаарлалтад авч, дэглэмжийг мөрдүүлэх	Тухай бүр	Аймаг, сумын Шуурхай штаб	Эрүүл мэндийн байгууллагууд
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР				
10	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас 5 хүртэлх насны хүүхэд, 65 ба түүнээс дээш насныхан, хавдар, уушиг, зүрх судасны архаг өвчин, чихрийн шижин, артерийн даралт ихсэх өвчтэй эрсдэлт бүлгийн иргэдийн судалгааг нэрсээр гаргуулан, тусламж үйлчилгээг үзүүлэх төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэх	01 дүгээр сарын 20-ны дотор	Эрүүл мэндийн алба Шуурхай хариу арга хэмжээний баг	Эрүүл мэндийн байгууллагууд
11	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд дэлгэх орны тооцооллыг шинэчлэн гаргаж, батлагдсан тохиолдлын эмнэлзүйн хүнд, хүндэвтэр зэргийг тусгаарлан эмчлэх ор, ажиллах хүний нөөц, шаардагдах хэрэгслийн бэлэн байдлыг хангах	Тухай бүр	Эрүүл мэндийн алба Шуурхай хариу арга хэмжээний баг	Эрүүл мэндийн байгууллагууд
12	Гэрийн эмчилгээ, хяналтад байгаа тохиолдлын эмнэлзүй хүндэрсэн нөхцөлд амбулаторийн үзлэг хяналт хийх цэгийг байгуулан, тусламж үйлчилгээг үзүүлэх	Тухай бүр	Нэгдсэн эмнэлэг сум, өрхийн Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газрын Шуурхай хариу арга хэмжээний баг
13	Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвд өвчлөлийн тохиолдол нэмэгдсэн үед хувийн хэвшлийн эмнэлэг, зэргэлдээ сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллахад анхаарах	Тухай бүр	Эрүүл мэндийн газар Нэгдсэн эмнэлгийн захирал, сумын Эрүүл мэндийн төв Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд
14	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхэд, төрөх, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн үйл ажиллагаанд онцгой анхаарч, шаардагдах эм хэрэгслийн нөөц, бэлэн байдлыг сайжруулах	Тухай бүр	Нэгдсэн эмнэлгийн захирал, Эмчилгээ эрхэлсэн дэд захирал	Эрүүл мэндийн газрын Шуурхай хариу арга хэмжээний баг

15	Ковид-19 халдварын дараах нөхөн сэргээх эмчилгээний хэсгийг эрүүл мэндийн байгууллага бүр ажиллуулж, үр дүнг тооцож, тусламж үйлчилгээнд хяналт тавьж ажиллах	Тогтмол	Нэгдсэн эмнэлгийн захирал, сумын Эрүүл мэндийн төвийн дарга нар	Эрүүл мэндийн байгууллагууд
16	Сэжигтэй тохиолдлуудад түргэвчилсэн оношлуураар оношилгоо хийх нөөцийг тасралтгүй бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд PCR шинжилгээний сорьц авах шинжилгээний орчин, урвалжийн нөөц, бэлэн байдлыг хангах	Тогтмол	Эрүүл мэндийн алба, төлөвлөлт, хяналт, нөөц, санхүү хөрөнгө оруулалтын баг	Аймаг, сумын Шуурхай штаб Эрүүл мэндийн байгууллагууд
17	Нэгдсэн эмнэлгийн лабораторийн PCR шинжилгээ хийхэд шаардлагатай урвалж бодисын нөөцийг бүрдүүлэх	Тогтмол	Нэгдсэн эмнэлгийн захирал	Аймгийн Эрүүл мэндийн газар
18	Хүүхдийн өвчлөлийн байдалд дүгнэлт хийж, хүндрэл, эндэгдлээс сэргийлэх арга хэмжээг авч, хэвтүүлэн эмчлэх орны нөөц, бэлэн байдлыг хангах	Тогтмол	Нэгдсэн эмнэлгийн захирал, сумын Эрүүл мэндийн төвийн дарга нар	Аймгийн Эрүүл мэндийн газар
19	Иргэдийн коронавируст халдвар (Ковид-19)-ын нэмэлт тунгийн хамралтыг эрчимжүүлэх, арга хэмжээг авах	Тогтмол	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	Аймаг, сумын шуурхай штаб Эрүүл мэндийн байгууллагууд
20	Эрүүл мэндийн байгууллагын ажилчдыг (Ковид-19)-ын нэмэлт тунгийн хамралтад бүрэн хамруулах	Тогтмол	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	Нэгдсэн эмнэлгийн захирал сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нар
ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР				
21	Эрсдэлийн үнэлгээний дагуу нөхцөл байдлын мэдээллийг тухай бүр гаргаж, иргэд олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах	Тухай бүр	Эрүүл мэндийн алба эрсдэлийн мэдээлэл харилцааны баг	Аймаг, сумын Шуурхай штаб Эрүүл мэндийн байгууллагууд
22	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын пэйж хуудсанд зөвлөгөө мэдээллийг тогтмол байршуулж хандалтыг нэмэгдүүлэхэд анхаарах	Тогтмол	Эрүүл мэндийн алба эрсдэлийн мэдээлэл харилцааны баг	Аймаг, сумын Шуурхай штаб Эрүүл мэндийн байгууллагууд
23	Иргэдэд болзошгүй халдвараас сэргийлэх, эрсдэлийг бууруулах тухай сэрэмжлүүлэг, сурталчилгааны мэдээ мэдээллийг бэлтгэн түгээх	Тогтмол	Эрүүл мэндийн алба эрсдэлийн мэдээлэл харилцааны баг	Аймаг, сумын Шуурхай штаб Эрүүл мэндийн байгууллагууд